



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/13

Онги

Хандив тусламжийн орлогын
дансны тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.5, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2024 оны 03 дугаар хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/83 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан малчин өрхөд өвс, тэжээлийн тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор хандив тусламжийн орлогыг төвлөрүүлэх, зардал гаргах, бүртгэх, тайлагнах асуудлыг сумын Засаг Даргын Тамгын газрын Төрийн сан банкандах 100081255401 тоот Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар гүйцэтгэж тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Болоржаргал)-д үүрэг болгосугай.

2. Хууль тогтоомжийн дагуу зарлага санхүүжилтийг зохион байгуулж, тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Болоржаргал), Санхүүгийн албаны дарга (Р.Тунгалагтуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА

D disk /2024on/A Zahiramj.doc

282701013

